



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 20

Номгон

┌ Албан тушаалын сул орон тоонд ┐
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Энэ оны 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан Л.Батбаярыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр, Баян-Овоо сумын газрын даамалаар Э.Түвшинжаргалыг, Соёл урлагийн газрын төсөв хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтнээр О.Сувд-Эрдэнийг, Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд хүний нөөц дотоод хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр Ш.Мартмааг, Жинст сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнээр Н.Эрдмааг, Мал эмнэлгийн газрын шимэгчлэх, халдваргүй өвчин малын эм биобэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтнээр Э.Одмааг, Баянхонгор сум дахь Мал эмнэлгийн тасгийн Тархварзүйчээр Ө.Цэвээнбатыг, Байгаль орчин аялал жуулчлалын газрын Баянбулаг сумын Байгаль хамгаалагчаар Л.Бямбасүрэнг тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2.Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.

ДАРГА  Д.ЭНХЖАРГАЛ

ГСТ 7/21
03

642213166